

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 -р сарын 15 өдөр

Дугаар 02/2024.

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал зарлан хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын холбогдох заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 14.00 цагт Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 тоот хаягаар орших компанийн өөрийн байр, хурлын танхимд хуралдуулсугай.
2. “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурдсан асуудлуудыг хэлэлцэхээр тогтоосугай:
 - Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтүүдийг хэлэлцэж батлах,
 - Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг батлах,
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох,
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.
3. 2024 оны 04 дүгээр сарын 27-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн П.Учралыг томилсугай.
4. Хурал зохион байгуулах комиссын даргаар Б.Ганбат, комиссын гишүүнээр Д.Дашмааг томилсугай.
5. Хурлын тооллогын комиссын даргаар М.Шавагцэрэн, комиссын гишүүнээр Ц.Болортуяа нарыг томилсугай.
6. Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хүргэх, хурлыг зарлан хуралдуулах ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комиссад даалгасугай.
7. Энэхүү ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөр тогтоосугай.
8. Хурал хуралдах тухай хувьцаа эзэмшигчдэд 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу мэдээлэхээр тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 1-ээр баталсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны загварыг Хавсралт 2-р баталсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн 15.00 цагаар тасалбар болгосугай.
12. Энэхүү тогтоол гарсан өдрөөс хойш 3 хоногийн дотор “Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг хурал зохион байгуулах комиссод даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



П. БИШРЭЛ